

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/88/НА-СТА-ТХН

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	хуудас:	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261628 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Аудитор Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал Л.Насанбуян Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com
---	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт.....	21
5.2 Албан шаардлага.....	21
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/408
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Н.ОДМӨНХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн 2,353.4 мянган төгрөгийн шатахууныг олгосон;
- Санхүүгийн тайлангийн жилд 47,207.8 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй;
- Тайлант хугацаанд худалдан авсан 5,523.5 мянган төгрөгийн хангамжийн болон бичиг хэргийн материалыг бараа материалын дансанд орлого бүртгээгүй, санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,851.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дах заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төслийн гүйцэтгэгч Пауэр констракшн корпорэйшн оф чайна компанид урьдчилгаа төлбөрийг Монгол Улсын Сангийн яамнаас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр, БНХАУ-ын Экспорт-Импорт банкнаас 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдөр олгосон байна. Иймд гэрээний дагуу ажил эхлэх нөхцөл бүрдэж энэ өдрийг “ажил эхлэх өдөр”-ийг тооцож барилгын ажил албан ёсоор эхэлсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгөх, уг ажилтай холбогдох аливаа гологдлыг засаж арилгах захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ЭХА-14/2021 дугаар гэрээний дагуу гүйцэтгэгчид олгосон БНХАУ-ийн экспорт импорт банкнаас олгосон хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө 272,408.6 сая төгрөг Монголын талаас олгосон 17,844.6 сая төгрөгийг урьдчилж төлсөн тооцоо буюу бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудал

Гүйцэтгэгч компани барилга угсралтын ажилд Ховд аймгаас 168, Баян-Өлгий аймгаас 115, нийт 283 иргэнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.А.Ц.* Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,060,670,612.00	290,659,103,943.08
33	АВЛАГА	422,100.00	433,100.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		11,000.00
335	Бусад авлага	422,100.00	422,100.00
3351	Байгууллагаас авах авлага	422,100.00	422,100.00
34	УРЬДЧИЛГАА	13,909,900,312.00	286,318,526,661.09
34600	Урьдчилж гарсан зардал	13,909,900,312.00	286,318,526,661.09
35	БАРАА МАТЕРИАЛ	30,978,200.00	47,207,800.00
354	Хангамжийн материал	30,978,200.00	47,207,800.00
35420	Аж ахуйн материал	1,620,000.00	5,599,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,440,000.00	1,440,000.00
35440	Түлш, шатах тослох материал		2,960,000.00
35470	Бусад хангамжийн материал	27,918,200.00	37,208,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	119,370,000.00	4,292,936,381.99
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	119,370,000.00	4,292,936,381.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	634,843,841.00	574,110,432.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	634,843,841.00	574,110,432.24
392	Биет хөрөнгө	486,141,340.95	425,825,932.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	465,200,000.00	465,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,455,555.54	-167,988,888.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	135,681,380.00	162,681,090.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-49,233,747.35	-67,851,052.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,939,300.00	55,789,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,990,036.16	-22,004,516.11
393	Биет бус хөрөнгө	148,702,500.05	148,284,500.09
39301	Программ хангамж	2,090,000.00	2,090,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-522,499.95	-940,499.91
39303	Бусад биет бус хөрөнгө	147,135,000.00	147,135,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,695,514,453.00	291,233,214,375.32
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	284.50	1,010,747.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	284.50	1,010,747.01
413	Өглөг	284.50	1,010,747.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	284.50	281.01
4136	Бусад өглөг	0.00	1,010,466.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		1,010,466.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,695,514,168.50	291,232,203,628.31
51	Засгийн газрын хувь оролцоо	14,695,514,168.50	291,232,203,628.31
51100	Засгийн газрын оруулсан капитал	27,887,880.00	27,887,880.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	27,887,880.00	27,887,880.00
512	Хуримтлагдсан үр дүн	14,667,626,288.50	291,204,315,748.31
51210	Өмнөх үеийн үр дүн	680,347,524.65	14,667,626,288.50
51220	Тайлант үеийн үр дүн	13,987,278,763.85	276,536,689,459.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,695,514,453.00	291,233,214,375.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,246,613,050.00	277,701,524,981.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	560,000.00	277,701,524,981.08
120	Нийтлэг татварын бус орлого	560,000.00	276,584,402,981.08
120009	Бусад орлого	560,000.00	2,210,250.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	272,408,626,349.09
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	4,173,566,381.99
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,117,122,000.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн орлого \УТ-ОН\	-	1,117,122,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,246,053,050.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,444,839,800.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,325,469,800.00	
131005	Хөрөнгийн санхүүжилт	119,370,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	801,213,250.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	801,213,250.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-11,740,665,713.85	1,164,835,521.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,169,234,598.15	1,164,835,521.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,961,071,505.05	1,123,846,443.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,736,150.37	688,122,231.00
210101	Үндсэн цалин	786,736,150.37	688,122,231.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,295,046.00	86,015,279.15
210201	Тэтгэврийн даатгал	66,840,631.00	49,502,922.89
210202	Тэтгэмжийн даатгал	7,863,603.50	16,389,232.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,931,802.25	3,115,271.88
210204	Ажилгүйдлийн даатгал	3,931,802.25	3,245,407.59
210205	Эрүүл мэндийн даатгал	15,727,207.00	13,762,444.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,640,000.00	88,830,000.00
210304	Байрны түрээс	80,640,000.00	88,830,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,310,204.78	16,289,009.05
210401	Бичиг хэрэг	4,425,000.00	4,158,155.00
210402	Тээвэр, шатахуун	6,208,000.00	7,536,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,998.78	884,170.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,694,206.00	3,710,284.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,712,600.00	11,010,000.00
210604	Урсгал засвар	7,712,600.00	11,010,000.00
2107	Томилолт, зочны зардал	52,039,610.00	76,547,950.00
210702	Дотоод албан томилолт	52,039,610.00	74,589,450.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		1,958,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	820,335,545.75	51,876,047.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	808,289,972.00	43,876,047.19

**Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,097,300.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	468,923.75	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	975,000.00	
210807	Газрын төлбөр	1,471,350.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,002,348.15	105,155,926.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,833,500.00	3,572,808.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	97,168,848.15	101,583,118.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,163,093.10	40,989,078.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	208,163,093.10	40,989,078.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	208,163,093.10	40,989,078.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,987,278,763.85	276,536,689,459.81
299970	Хөрөнгө оруулалт, техник хяналт барьцаа	13,909,900,312.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,987,278,763.85	276,536,689,459.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,127,243,050.00	1,118,012,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	560,000.00	1,118,012,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	560,000.00	890,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	560,000.00	890,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	560,000.00	890,250.00
122	Тусламжийн орлого	-	1,117,122,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,117,122,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,117,122,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,117,122,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,126,683,050.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,325,469,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,325,469,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	801,213,250.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	801,213,250.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,098,846,050.00	1,118,012,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,098,846,050.00	1,118,012,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,890,682,956.90	1,077,023,171.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,736,150.37	687,111,769.43
210101	Үндсэн цалин	786,736,150.37	687,111,769.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,295,046.00	86,026,278.21
210201	Тэтгэврийн даатгалын зардал	66,840,631.00	58,650,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	7,863,603.50	6,900,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,931,802.25	3,450,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,931,802.25	3,426,278.21
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	15,727,207.00	13,600,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,640,000.00	88,830,000.00
210304	Байрны түрээс	80,640,000.00	88,830,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,903,204.78	18,450,809.05
210401	Бичиг хэрэг	4,425,000.00	4,158,155.00
210402	Тээвэр, шатахуун	6,208,000.00	9,446,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	982,998.78	1,334,170.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,287,206.00	3,512,084.00
2105	Нормативт зардал	19,998,000.00	9,488,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,998,000.00	9,488,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,479,800.00	40,849,710.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	26,999,710.00
210602	Тавилга	-	13,850,000.00
210604	Урсгал засвар	14,479,800.00	-
2107	Томилолт, зочны зардал	52,461,710.00	75,827,950.00
210702	Дотоод албан томилолт	52,461,710.00	73,869,450.00

**Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	1,958,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	820,335,545.75	66,865,847.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	808,289,972.00	58,865,847.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,097,300.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	468,923.75	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	975,000.00	-
210807	Газрын төлбөр	1,471,350.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,833,500.00	3,572,808.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,833,500.00	3,572,808.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,163,093.10	40,989,078.12
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	40,989,078.12
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	40,989,078.12
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,989,078.12
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	40,989,078.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	208,163,093.10	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,019,815.10	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	6,143,278.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	28,397,000.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	28,397,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,397,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	28,397,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,397,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(28,397,000.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,887,880.00		680,347,524.65	708,235,404.65
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,887,880.00	0.00	680,347,524.65	708,235,404.65
9	Тайлант үеийн үр дүн			13,987,278,763.85	13,987,278,763.85
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,887,880.00	0.00	14,667,626,288.50	14,695,514,168.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,887,880.00	0.00	14,667,626,288.50	14,695,514,168.50
19	Тайлант үеийн үр дүн			276,536,689,459.81	276,536,689,459.81
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	27,887,880.00	0.00	291,204,315,748.31	291,232,203,628.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	273,526,122,000.00	273,526,638,599.08	(516,599.08)	100.0
12	Татварын бус орлого	1,117,122,000.00	1,117,122,000.00	-	100.0
122	Тусламжийн орлого	1,117,122,000.00	1,117,122,000.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	1,117,122,000.00	1,117,122,000.00	-	100.0
120009	Бусад орлого		890,250.00	(890.250.00)	0.0
123005	Гадаадын эх үүсвэрийн санхүүжилтийн орлого	272,409,000,000.00	272,408,626,349.08	373,650.92	99.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	273,526,122,000.00	273,526,638,599.08	40,098,828.12	96.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,117,122,000.00	1,077,023,171.88	40,098,828.12	96.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,117,122,000.00	1,077,023,171.88	40,098,828.12	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,000,000.00	687,111,769.43	2,888,230.57	99.6
210101	Үндсэн цалин	690,000,000.00	687,111,769.43	2,888,230.57	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,250,000.00	86,026,278.21	223,721.79	99.7
210201	Тэтгэврийн даатгал	58,650,000.00	58,650,000.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,900,000.00	6,900,000.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,450,000.00	3,450,000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,450,000.00	3,426,278.21	23,721.79	99.3
210205	Эрүүл мэндийн даатгал	13,800,000.00	13,600,000.00	200,000.00	98.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,210,000.00	88,830,000.00	10,380,000.00	89.5
210304	Байрны түрээс	99,210,000.00	88,830,000.00	10,380,000.00	89.5
2104	Хангамж, бараа материалын зардал	24,962,000.00	18,450,809.05	6,511,190.95	73.9
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	4,158,155.00	341,845.00	92.4
210402	Тээвэр, шатахуун	12,800,000.00	9,446,400.00	3,353,600.00	73.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,162,000.00	1,334,170.05	1,827,829.95	42.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	3,512,084.00	987,916.00	78.1
2105	Нормативт зардал	9,500,000.00	9,488,000.00	12,000.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,500,000.00	9,488,000.00	12,000.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,600,000.00	40,849,710.00	7,750,290.00	84.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,600,000.00	26,999,710.00	7,600,290.00	78.0
210602	Тавилга	14,000,000.00	13,850,000.00	150,000.00	98.9
2107	Томилолт, зочны зардал	76,000,000.00	75,827,950.00	172,050.00	99.8
210702	Дотоод албан томилолт	74,000,000.00	73,869,450.00	130,550.00	99.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	1,958,500.00	41,500.00	97.9

**Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,000,000.00	66,865,847.19	12,134,152.81	84.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,000,000.00	58,865,847.19	12,134,152.81	82.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00	3,572,808.00	27,192.00	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600,000.00	3,572,808.00	27,192.00	99.2
213	Урсгал шилжүүлэг	0.00	40,989,078.12	(40,989,078.12)	0.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	40,989,078.12	(40,989,078.12)	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	40,989,078.12	(40,989,078.12)	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	272,409,000,000.00	272,408,626,349.08	373,650.92	99.9
220001	Барилга байгууламж	272,409,000,000.00	272,408,626,349.08	373,650.92	99.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	16	2	88.9
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	15	2	88.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний сайдын 2015 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 72 дугаар тушаалаар Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн нэгжийг байгуулсан.

Тус төсөл нь 2028 он хүртэлх хугацаанд хэрэгжих бөгөөд цахилгаан эрчим хүчний хэрэглээний тасралтгүй өсөлт, бие даасан байдал, аюулгүй ажиллагааг хангахад их багтаамжтай нөөцлүүр, горим тохируулгын үүрэг гүйцэтгэх усан цахилгаан станц барих зорилготой Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний төслийн нэгж юм.

Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 160 дугаар тогтоолоор баталсан БНХАУ-ын Засгийн газрын 1000.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн жагсаалтад Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл багтсан байна.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг 2024.11.01-ний өдөр байгуулсан. БНХАУ-ын Экспорт-Импорт банкнаас Зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдлын тухай мэдэгдлийг 2024.12.26-ны өдөр ирүүлсэн.

Төслийн зорилго нь баруун бүсийн болон эрчим хүчний нэгдсэн системийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг найдвартай эх үүсвэрээр хангах, баруун бүсийн эрчим хүчний системийн горим тохируулгын үүрэг гүйцэтгэх, эрчим хүчний системийн аюулгүй байдлыг хангах, импортын эрчим хүчний хэмжээг багасган бүс нутгийн эдийн засгийн чадавхыг сайжруулах ач холбогдол бүхий 90 мвт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн үйл ажиллагаанд дараах хууль эрх зүйн актыг мөрддөг байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын 2025.01.03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”.

Төслийн нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муутай байна.

Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар төслийн нэгжийн санхүүгийн болон үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төслийн нэгж Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, төсөл хэрэгжүүлэх заавар, Зээлийн ерөнхий хэлэлцээр, Сангийн яамны баталсан төслийн санхүүгийн удирдлагын гарын авлагыг мөрдлөг болгон ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 276,537,699.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	422.1	433.1	11.0
Урьдчилгаа	13,909,900.3	286,318,526.7	272,408,626.4
Бараа материал	30,978.2	47,207.8	16,229.6
Бусад эргэлтийн хөрөнгө	119,370.0	4,292,936.4	4,173,566.4
Үндсэн хөрөнгө	634,843.8	574,110.4	-60,733.4
Нийт хөрөнгө	14,695,514.5	291,233,214.4	276,537,699.9
Өр төлбөр	0.3	1,010.8	1,010.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,695,514.2	291,232,203.6	276,536,689.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,695,514.5	291,233,214.4	276,537,699.9

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан төслийн ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансууд байна. Тухайлбал:

- Урьдчилгаа дансны үлдэгдэл 286,318,526.6 мянган төгрөг байгаа нь төслийн гүйцэтгэгч Пауэр Чайна-Пауэр Чайна Чэнгдү түншлэл компанийн олгосон 30 хувийн урьдчилгаа төлбөр 79.9 сая ам.доллар буюу Монголын талын хариуцах 5 хувийн санхүүжилтээс гарсан 13,671,099.5 мянган төгрөг, БНХАУ-ын Экспорт Импорт банкнаас шилжүүлсэн 272,408,626.3 мянган төгрөгийн төлбөрийг бүртгэсэнтэй холбоотой.
- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд тайлант онд Монголын талын хариуцах 5 хувийн санхүүжилтээс гарсан гүйцэтгэл нэмэгдсэнээр 4,292,936.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон;

- Бараа материалын үлдэгдэл 16.229.6 мянган төгрөгөөр өссөн бөгөөд тус дансанд 2,960.0 мянган төгрөгийн шатахууны, 13,467.8 мянган төгрөгийн ашиглалтад байгаа хангамжийн материалын үлдэгдэл байна;
- Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 60,733.4 мянган төгрөгөөр буурсан нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 40,849.7 мянган төгрөгийн тавилга, компьютер худалдаж авч, 101,583.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэнтэй холбоотой байна;
- Засгийн газрын хувь оролцооны дансны өсөлт нь төслийн гүйцэтгэлээр олгосон санхүүжилттэй хамааралтай байна;
- Программ хангамжийн тухайд Санхүүгийн тооцоолох ХХК-ийн fiscus online программыг 2023 оноос нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахад ашиглаж байна. Санхүүгийн тайланд биет бус хөрөнгийн ангилалд 2,090.0 мянган төгрөгийн үнэтэй байна. Санхүүгийн тооцоолох ХХК тухай бүр хөгжүүлэлт хийдэг. Тайлант жилд 660.0 мянган төгрөгийн хөгжүүлэлтийн үйлчилгээний төлбөр төлсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,638,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон тоо дутуу ажиллаж байснаас шалтгаалан цалингийн зардлыг 310,000.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 38,000.0 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 130,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 26,000.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,117,122.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгээгүй. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,117,122.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,117,122.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны нийт зардлын гүйцэтгэл 1,077,023.2 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байна. Улсын төсөвт 40,098.8 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл Үүнээс:	1,117,122.0	1,077,023.2	40,098.8	96.4%
1	Цалингийн зардал	690,000.0	687,111.8	2,288.3	99.6%
2	НДШ-ажил олгогч	86,250.0	86,026.3	223.7	99.7%
3	Байрны түрээс	99,210.0	88,830.0	10,380.0	89.5%
4	Бичиг хэрэг, хангамжийн материалын зардал	24,962.0	18,450.8	6,511.2	73.9%
5	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,500.0	9,488.0	12.0	99.8%
6	Эд хогшил, урсгал засварын зардал	48,600.0	40,849.7	7,750.3	84.0%
7	Томилолт, зочны зардал	76,000.0	75,827.8	172.0	99.7%
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,000.0	66,865.8	12,134.1	84.6%
9	Бараа үйлчилгээний бусад зардал	3,600.0	3,572.8	27.2	99.2%

Тайлант хугацаанд Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд хамаарах зардал гараагүй. Ажилчид нь хөлсөөр ажиллах гэрээгээр ажилладаг тул хоол, унааны нөхөх олговор олгодоггүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төсөл”-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төслийн удирдах хорооны 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан байна.

Төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 9 хэсгийн хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь 94 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн удирдах хорооны 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, төсөл хэрэгжүүлэх нэгжийн урсгал үйл ажиллагаанд зориулан 6 нэр төрлийн 58,100.0 мянган төгрөгийн барааг шууд гэрээ байгуулах, байгаль орчин менежментийн төлөвлөгөөний дагуу 100,000.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 3 .Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Нэр төрөл	Төсөвт өртөг	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Кемпийн тавилга болон гал тогооны тавилга хэрэгсэл	14,000.0	13,850.0
2	Кемпийн цахилгааны холболт болон цэвэр усны холболт	6,600.0	6,400.0
3	Кемпийн принтер А3 хэвлэдэг /2 ширхэг/	8,000.0	7,119.8
4	Хурлын тоног төхөөрөмжийн иж бүрдэл /төслийн нэгж/	11,000.0	10,905.0
5	Хурлын тоног төхөөрөмжийн иж бүрдэл /кемп/	9,000.0	8,990.0
6	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,500.0	9,488.0
7	Нуур үүсэх талбайн түүх, соёлын өвийн дурсгалт зүйлсийн хяналтын тооллого, судалгааны ажил	100,000.0	94,949.9
	Нийт	158,100.0	151,702.6

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах гүйцэтгэлийн акт, баримтыг баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, туслах аудитор Ж.Золжаргал нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Л.Насанбуян нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямсүрэн, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,169,234.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,692.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны зардлыг хэмнэлттэй ажиллах тал дээр анхаарч ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 748,191.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулбал зохих нийт 157 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 748,191.7 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, зарлагын 5 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус төслийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй тул асуудлын бүртгэл гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн, аудитаар 1,183.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,388,176.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгсөн нь шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,183.5	2	1,183.5	100
Албан шаардлага	3	1,388,176.8	3	1,388,176.8	100
Нийт дүн	5	1,389,360.3	5	1,389,360.3	100

Өмнөх жилийн аудитаар албан шаардлага өгсөн Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд харьяалагдах нуур үүсэх талбайд байрлах Казак иргэдийн булш, бунхныг нүүлгэн шилжүүлэх ажилтай холбоотой 596,131.2 мянган төгрөгийн зөрчил нь хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын А/З дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байгааг анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,728.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд, 2,353.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 21,374.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 23,728.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,035.8 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай дүгнэлт” өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн 2,353.4 мянган төгрөгийн шатахууныг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн “16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Зам, тээврийн хөгжлийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан жишиг нормыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн олгосон шатахууны төлбөрийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Санхүүгийн тайлангийн жилд 47,207.8 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллогыг хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2. Тайлант хугацаанд худалдан авсан 5,523.6 мянган төгрөгийн хангамжийн болон бичиг хэргийн материалыг бараа материалын дансанд орлого бүртгээгүй, санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын бараа материалын бүртгэлтэй холбоотой заалтыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд худалдан авсан бичиг хэрэг, хангамжийн материалыг санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,851.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн шатахууныг олгосон байна.	1	2,353.4	1	2,353.4								
2	Тайлант хугацаанд худалдан авсан 5,523.5 мянган төгрөгийн хангамжийн болон бичиг хэргийн материалыг бараа материалын дансанд орлогоор бүртгээгүй, санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан байна.	1	5,523.6			1	5,523.6						
3	Анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,851.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэлийн засвар үйлчилгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.	1	15,851.1					1	15,851.1				
4	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийхдээ 47,207.8 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй байна.	1	-			1	-						
	Дүн	4	23,728.1	1	2,353.4	2	5,523.6	1	15,851.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 157 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 712,191.7 мянган төгрөгийн орлогын 7 гүйлгээ, 36,000.0 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна	1	748,191.7	1	748,191.7		
	Дүн	1	748,191.7	1	748,191.7		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 56/A0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/98/НА - СТА - ТХН

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн 2,353,432.00 (Хоёр сая гурван зуун тавин гурван мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийн шатахууныг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн "16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Зам, тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан жишиг нормыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан тээврийн хэрэгсэлд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормоос хэтрүүлэн олгосон 2,353,432.00 (Хоёр сая гурван зуун тавин гурван мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлт, нотлох баримтыг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн зохицуулагч /Н.Одмөнх/, нягтлан бодогч /Х.Галсанхүү/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баян тойруу 23, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-26.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 277/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/88/НА - СТА - ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн жилд 47,207,800.00 /Дөчин долоон сая хоёр зуун долоон мянга найман зуун/ төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-р зүйлийн 2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын тооллогыг хийгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлт, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн зохицуулагч /Н.Одмөнх/, нягтлан бодогч /Х.Галсанхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 278/АД150092

Улаанбаатар хот

САГ-2026/88/НА-СТА-ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд худалдан авсан 5,523,555.00 /Таван сая таван зуун хорин гурван мянга таван зуун тавин таван/ төгрөгийн хангамжийн болон бичиг хэргийн материалыг бараа материалын дансанд орлого бүртгээгүй, санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын бараа материалын бүртгэлтэй холбоотой заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант хугацаанд худалдан авсан бичиг хэрэг, хангамжийн материалыг санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан зөрчлийг арилгаж, биелэлт, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн зохицуулагч /Н.Одмөнх/, нягтлан бодогч /Х.Галсанхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага Тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-33.Docx

1526180592



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 279/А0150092

Улаанбаатар хот

САГ - 2026/88/НА - СТА - ТХИ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 157 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 748,191,728.00 /Долоон зуун дөчин найман сая нэг зуун ерэн нэгэн мянга долоон зуун хорин найман/ төгрөгийн орлогын 7 гүйлгээ, зарлагын 5 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроож байршуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлт, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн зохицуулагч /Н.Одмөнх/, нягтлан бодогч /Х.Галсанхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125_SAG-33.Docx

1526180594